



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 7 дугаар сарын 01 өдөр

Дугаар 29/011

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлыг томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.9 дэх заалт, 83 дугаар зүйлийн 83.7 дэх заалт болон Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 10 дугаартай тогтоолын хавсралтаар баталсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох заалтыг тус тус үндэслэн тогтоох нь:

1. Айтүүлс ХК-ийн Гүйцэтгэх захирал Баярсайханы Тамир /ЕП87050309/-ыг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. Чимэдхишигийн Мөнхжаргал /УШ75040306/-г Айтүүлс ХК-ийн Гүйцэтгэх захирлаар 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж Ч.Мөнхжаргалтай Хөдөлмөрийн гэрээ байгуулан, ажлын байрны тодорхойлолт болон гэрээний холбогдох хавсралтын хувийг хүлээлгэн өгөхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Гантулгын Хатанболдод зөвшөөрсүгэй.
4. Компанийн ажилтнуудын ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлж, компанийн үйл ажиллагаанд технологийн стандартыг мөрдүүлж, гэрээнд заагдсан эрх үүргийн дагуу хууль тогтоомжийн хүрээнд борлуулалт, ашгийн хэмжээг нэмэгдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Мөнхжаргалд даалгасугай.
5. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг улирал бүр Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж байхыг Гүйцэтгэх захирал Ч.Мөнхжаргалд үүрэг болгосугай

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Г.ХАТАНБОЛД